

СОНГУУЛИЙН НЭГДСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ

Д/д	Саналын томъёолол	Үндэслэл, тайлбар
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ		
1	"Хорих газар ял эдэлж байгаа" гэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих болон баривчлах ял эдэлж байгаа болон хорих, баривчлах ял эдлэхээс зайлсхийж яваа, хорих байгууллагаас түр чөлөөгөөр гарсан иргэнийг;	"Хорих газар ял эдэлж байгаа" гэсэн ойлголтыг энд дурьдсанаар томъёолох.
2	"Сонгуулийг санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана."	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг сонгуулийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор автоматжуулсан системийн иж бүрдлийг бэлтгэх болон сонгуулийн бусад бэлтгэл ажилтай холбоотойгоор сонгуулийг 65-с доошгүй хоногийн өмнө товлон зарлахаар тогтоох
3	"онцгой нөхцөл байдал үүссэн" гэдэгт сонгуулийг зохих ёсоор явуулахад урдчилан төлөвлөөгүй бөгөөд төлөвлөх боломжгүй, нэмэлт зардал, хөрөнгө зарцуулагдах зайлшгүй шаардлага бий болсныг ойлгоно.	Сонгуулийн хуульд зааснаар хэсгийг нэгтгэх, шинээр байгуулах, сонгогчдыг тухайн хэсгээс тусгаарлах үндэслэл нь онцгой нөхцөл байдал үүссэн байх явдал байдаг. Иймд уг ойлголтыг тодорхойлж хуульчлах.
4	"байгалийн гамшиг" гэдэгт хүний үйл ажиллагаанаас үл хамаарах аюулт үзэгдлийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрах буюу байгалийн хүчний үйлчлэлийн үр дагавар болох онцгой нөхцөл байдал;	Сонгуулийн хуульд зааснаар хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох үндэслэлд "байгалийн гамшиг" хамаардаг тул уг ойлголтыг тодорхойлж хуульчлах.
5	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулж, харьяалах сонгуулийн хороодод хуваарилан зарцуулалтад хяналт тавьж ажиллана.	Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг доод шатны сонгуулийн хороод зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих, зардлыг хуваарилахдаа харгалзан үзэх үзүүлэлтүүдийг тодорхой болгох.
6	Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн батлагдсан зардлыг зохих эдийн засгийн ангиллын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн болон сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороо, мэдээлэл технологийн баг тэдгээрт ажиллах гишүүд, мэдээллийн технологийн даамлын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хянаж хуваарилна.	Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг доод шатны сонгуулийн хороод зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих, зардлыг хуваарилахдаа харгалзан үзэх үзүүлэлтүүдийг тодорхой болгох.

7	Сонгуулийн хороод хуваарилсан зардлыг зориулалтын дагуу захиран зарцуулах ба эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэхийг хориглоно. Шаардлагатай тохиолдолд Сонгуулийн Ерөнхий Хорооны зөвшөөрлөөр шилжүүлж болно.	Сонгуулийн хороод хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэхгүй байснаар тухайн зардлыг зориулалтын дагуу захиран зарцуулна. Зайлшгүй тохиолдолд Сонгуулийн Ерөнхий Хороонд хүсэлтээ тавьж шийдвэрлүүлнэ.
8	Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн хороодын зардлын дансыг Төрийн сангийн газарт нээлгэн, сонгууль дууссаны дараа зохих журмын дагуу хаалгана.	Сонгуулийн хороодын зардлын дансыг Төрийн сангийн газарт нэгдсэн журмаар нээлгэж, хаалгадаг байх.
9	Төрийн сангийн газарт нээлгэсэн сонгуулийн хорооны зардлын дансыг зөвхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд ашиглах бөгөөд бусад үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.	Төрийн сангийн газарт нээлгэсэн сонгуулийн зардлын дансны зориулалтыг тодорхой хуульчлах.
10	Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.	Сонгуулийн хороодын сонгуулийн зардлын дансны гүйлгээг хянахад ашиглагдах санхүүгийн баримтуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлдөг байх.
11	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулсан байна.	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сонгуулийн зардлын нэгдсэн тайлангаа тухайн аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулан Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлдэг байх.
12	Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн зардлын тайланг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо тус бүрээр хянан хүлээн авч нэгтгэн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн нэгдсэн тайланг гаргана.	Сонгуулийн Ерөнхий Хороо аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос ирүүлсэн тайланг хянаж сонгуулийн зардлын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан гаргадаг байх.
13	Сонгуулийн Ерөнхий Хороо аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны тайланг хянан үзэх зорилгоор иргэн, хуулийн этгээд, банк, аудитын байгууллагаас баримт, тодруулгыг гаргуулан авч болно.	Сонгуулийн Ерөнхий Хороо аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос ирүүлсэн тайланг хянан үзэхдээ холбогдох этгээдээс тодруулга авах эрхтэй байх.
14	Шаардлагатай гэж үзвэл Сонгуулийн Ерөнхий Хороо аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны зардлын гүйцэтгэл, тайланг төрийн аудитын байгууллагаар шалгуулж, дүгнэлт гаргуулна.	Сонгуулийн Ерөнхий Хороо аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос ирүүлсэн тайланг төрийн аудитын байгууллагаар шалгуулж, дүгнэлт гаргуулах эрхтэй байх.
СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭН ЭРХ		

15	"Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугчдын байнга оршин суугаа газрын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана."	Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид хэсэг байгуулахдаа Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзаж, сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө байгуулахаар хуулийн төсөлд тусгах нь сонгууль зохион байгуулах ажлын цаг хугацааны хувьд тохиромжтой юм.
16	"Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсэгт сонгуулийн хэсгийн хороо /цаашид "хэсгийн хороо" гэх/ тус тус зохион байгуулж явуулна."	Сонгуулийн хороодыг тойргийн хороо, нутаг дэвсгэрийн хороо, салбар хороо, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо гэх мэт сонгууль болгоноор өөр өөрөөр нэрлэж байсныг өөрчилж, сонгуулийн хороодын нэрийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, сум, дүүргийн сонгуулийн хороо гэх.
17	"Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын, аймаг, нийслэлийн сонгуулийн хороод нь сум, дүүргийн сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд ажиллах төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын судалгааг Төрийн албаны зөвлөл болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тус тус гаргуулан авч сонгууль зохион байгуулах ажлын дадлага туршлага, төрийн албан хаагчийн ёс зүйг харгалзан үзэж томилно."	Бүх шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд ажиллах төрийн захиргаан болон үйлчилгээний албан хаагчдад ёс зүйн болон сонгууль зохион байгуулах ажлын дадлага туршлагын тодорхой шалгуур тавигдсанаар сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд ажиллах төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
18	"Сонгуулийн хороод нь Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан хуралдааны дэгийг баримтлах ба гишүүдийн ажил үүргийн хуваарийг өөрөө тогтооно."	Бүх шатны сонгуулийн хороодын хуралдааны дэгийг Сонгуулийн Ерөнхий Хороо баталснаар сонгуулийн хороодын хуралдаан ижил нэг дэгийн дагуу зохион байгуулагдах боломжийг бүрдүүлнэ.
19	"Нам, эвслээс нэр дэвшигч болон бие даан нэр дэвшигч нь өөрийн харьяалагдах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугч байна."	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчид тавигдах шаардлагад тусгайлан тусгах нь зүйтэй юм. Учир нь орон нутгийн сонгуулиар нутгийн өөрөө удирдах байгууллагад тухайн орон нутгийнхаа төлөөлөгчийг сонгодог онцлогтой.
20	Сонгуулийн хороод тус тусын чиг үүрэгт хамаарах баримт бичгүүдийг бүртгэн цэгцэлж, санал хураалт дууссаны дараа хэсгийн хороод сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус хүлээлгэн өгнө.	Тухайн шатны сонгуулийн хороонд үйлдэгдсэн сонгуулийн баримт бичгийг дээд шатны сонгуулийн хороонд бүрэн гүйцэд хүлээж авдаг байх.

21	Сонгуулийн баримт бичгийн бүртгэлийг цаг хугацааны дараалал, төрөл тус бүрээр сонгуулийн хороодын ажил үүргийн хуваариар үүрэг хүлээсэн гишүүн тусгай дэвтэрт хөтөлнө.	Сонгуулийн баримт бичгийг хүлээж авахдаа хүлээн авсан баримт бичиг бүрийн нэрийг тодорхой бүртгэж авдаг байх шаардлагатай.
22	Сонгуулийн баримт бичгийг холбогдох этгээд бүртгэхдээ тухайн баримт бичигт гарын үсэг зурж, тэмдэг дарсан эсэхийг нягтлан шалгана.	Сонгуулийн баримт бичгийг бүртгэж хүлээн авахдаа тухайн сонгуулийн баримт бичиг зохих журмын дагуу баталгаажсан эсэхийг нягтлан шалгадаг байх.
23	Сонгуулийн баримт бичгийг бүртгэхдээ сонгуулийн хороод шаардлагатай гэж үзсэн баримт бичгийн эх хувийг тулган шалгах зорилгоор нам, эвсэл, хамтарсан намууд, түүний сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчээс шаардан авч болно.	Сонгуулийн хороод баримт бичгийг бүртгэж хүлээн авахдаа шаардлагатай баримт бичгийн эх хувийг холбогдох этгээдээс гаргуулан авах эрхтэй байх.
24	Сонгуулийн баримт бичгийн бүртгэлийн дэс дугаар, он сар өдөр, доторх агуулгыг өөрчлөх, солих, засвар оруулах, бичигдсэн зүйлийг дарахыг хориглоно.	Зохих журмын дагуу нэгэнт баталгаажсан сонгуулийн баримт бичигт аливаа засвар, өөрчлөлт оруулах, үрэгдүүлэхийг хориглох.
25	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга сонгуулийн дүнгийн тухай хуралдааны тэмдэглэл, ажлын тайлан, нэгдсэн дүн, саналын хуудасны зарцуулалтын тайлан, хэсгийн хорооны санал тоолсон дүнгийн тухай хуралдааны тэмдэглэл, санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүн мэдээ, сонгуулийн зардлын тайлан, сонгуулийн автоматжуулсан систем ашиглан үйлдсэн баримт бичиг зэргийг Сонгуулийн Ерөнхий Хороонд хүлээлгэн өгнө.	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос Сонгуулийн Ерөнхий Хороонд зайлшгүй ирүүлэх баримт бичгүүдийг нэр зааж хуульчлах.
26	Сонгуулийн баримт бичгийг хүлээлцсэн тухай тэмдэглэл үйлдэж, хүлээлцэхэд байлцсан гишүүд, архивын эрхлэгч тус тус гарын үсэг зурж зохих журмын дагуу хадгална.	Сонгуулийн баримт бичгийг хүлээлцэхдээ тодорхой журмын дагуу хүлээлцдэг байх.
27	Сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэлийг бүхэлд нь гараар болон дуу хураагуурт бичиж хөтөлнө. Шаардлагатай гэж үзвэл дүрс бичлэг хийж болно.	Сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэл хөтлөх зөвшөөрөгдсөн хэлбэрийг заах.
28	Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гарын үсэг зурахаас татгалзахыг хориглоно.	Сонгуулийн хороод өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хуралдсан бол тухайн хуралдаанаас гарсан тэмдэглэлд дарга, нарийн бичгийн дарга, шаардлагатай тохиолдолд гишүүд гарын үсэг зурж баталгаажуулдаг байх. Энэ үүргээсээ хүндэтгэх шалтгаангүйгээр татгалзахыг хориглох.

29	Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлд тус тус гарын үсэг зурж, Хорооны тэмдэг дарж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд хорооны гишүүд гарын үсэг зурж болно.	Хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах хэлбэрийг заах.
30	Хэсгийн хорооны болон санал авах байрны харуул хамгаалалт, аюулгүй байдлыг сонгуулийн хороод, тухайн шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, онцгой байдлын алба хариуцан гал, усны зэрэг гэнэтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.	Хэсгийн хорооны болон санал авах байрны аюулгүй байдлыг хангах шаардлагыг хуульчлах.
31	Хууль болон холбогдох журамд зааснаар дээд шатны сонгуулийн хороонд сонгуулийн баримт бичгүүдийг бүрэн хүлээлгэн өгсөн сонгуулийн хорооны бүрэн эрхийг дуусгавар болгож татан буулгах тухай шийдвэрийг тухайн шатны сонгуулийн хороо холбогдох баримт бичгүүдийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор гаргаж, энэ тухай нийтэд мэдээлнэ.	Сонгуулийн дараа тухайн сонгуулийн хорооны үйл ажиллагааг дуусгавар болгож, татан буулгах хугацааг тодорхой зааж өгөх нь зүйтэй байна.
32	Сонгуулийн санал тоолох, дүн гаргах, дамжуулах болон сонгогчийн бүртгэл хөтлөх техник хэрэгсэл, програм хангамжийн ажиллагааг шалган туршиж, баталгаажуулах ажиллагаанд сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, хамтарсан намууд болон бие даан нэр дэвшигчдээс томилогдсон төлөөллийг байлцуулна.	Сонгуулийн санал тоолох, дүн гаргах, дамжуулах болон сонгогчийн бүртгэл хөтлөх техник хэрэгсэл, програм хангамжийн ажиллагааг шалган туршиж, баталгаажуулах ажиллагааг нээлттэй, ил тод болгох нь олон нийтэд буруу ташаа мэдээлэл хүрэхээс сэргийлэх, сонгуульд оролцогчдын итгэлийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой.
НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ		
33	"Аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороод бие даан нэр дэвшигчийн дэмжигч сонгогчдын гарын үсэг зуруулах маягтыг тэмдэг дарж олгоно."	Ингэснээр нэр дэвшүүлэх ажиллагааг хуульд заасан цаг хугацаанд зэрэг эхлүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.
34	"Нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш 10 хоногийн дараа эхлүүлж, 7 хоногийн хугацаанд дуусгана."	Сонгуулийг сонгуулийн автоматжуулсан системээр зохион байгуулж буй тохиолдолд саналын хуудаст нэр дэвшигчдийн нэрийг байрлуулах, нэр дэвшигчдийн нэрийг санал тоолох төхөөрөмжид программчлах, программ хангамжийг шалган турших хугацаа шаардлагатай байдаг.
35	"Аль нэг намын гишүүнийг өөр намын өмнөөс нэр дэвшүүлж үл болно. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ нь намын гишүүнээс түдгэлзсэн албан тушаалтанд нэгэн адил хамаарна."	Сонгуулиар аль нэг намын гишүүнийг өөр намын өмнөөс дэвшүүлэх оролдлогууд гарч байсан болно.

36	<p>“...Гарын үсэг хуурамчаар үйлдвэл ...” гэдэгт бүх төрлийн арга хэрэглэн (өөрөө, эсхүл өөр этгээдээр үйлдүүлэх, техник хэрэгсэл ашиглах г.м.) бусдын гарын үсгийг дуурайлгаж буюу хуулбарлаж, эсхүл зохиож зурахыг ойлгоно. Түүнчлэн сонгуулийн эрхгүй хүмүүсээр гарын үсэг зуруулсан зэргийг хамааруулан ойлгоно. Харин саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогчийн өмнөөс, түүний зөвшөөрснөөр итгэмжилсэн хүн нь гарын үсэг зурсан байж болно.</p>	<p>Бие даан нэр дэвшигч өөрийн дэмжигч, сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа хуурамчаар үйлдэх тохиолдол их гардаг. Иймд гарын үсэг хуурамчаар үйлдэх гэдэг ойлголтыг тодорхой болгон хуульчлах нь зүйтэй байна.</p>
37	<p>"Тухайн шатны сонгуулийн хороо бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын мэдээлэл үнэн зөв эсэхийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан сонгогчдын нэрийн жагсаалт, оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй түүвэрлэн тулгах буюу шаардлагатай бол тухайн иргэнтэй уулзаж нягтлан шалгах бөгөөд уг ажлыг хэсгийн хороогоор гүйцэтгүүлж болно."</p>	<p>Бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлах ажиллагаанд уг зарчмыг баримтлах нь зүйтэй. Учир нь сонгуулийн үеэр бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын мэдээллийг нэг бүрчлэн шалгах техникийн болоод цаг хугацааны боломжгүй бөгөөд энэ нь нөгөө талаар бие даан нэр дэвшигчийг сонгуульд хариуцлагатай өрсөлдөх шаардлага болно.</p>
38	<p>"Нэг намаас дэвшүүлсэн хүний нэрийг өөр нам тухайн сонгуульд дэвшүүлэхгүй бөгөөд нэг хүний нэрийг зөвхөн нэг сонгуульд нэр дэвшүүлнэ."</p>	<p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулиар аймгийн ИТХ-д нэр дэвшсэн хүн сумын хуралд давхар нэр дэвших тохиолдлууд гарч байсан болно. УИХ-ын болон ИТХ-ын сонгууль хамт явагдсан тохиолдолд нэг хүн зөвхөн тухайн сонгуульдаа нэр дэвших</p>
39	<p>“гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан” гэдэгт эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар нотлогдож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор уг этгээдийг яллагдагчаар татах тухай тогтоол үйлдсэн байхыг ойлгоно.</p>	<p>Гэмт хэрэгт яллагдагчаар татагдах гэдэг ойлголтыг тодорхой хуульчлах.</p>
<p>СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СУРТАЛЧИЛГАА</p>		
40	<p>"Нэр дэвшигчдээс томилсон ухуулагч, шадар туслагч нар сонгуулийн санал хураалтын өдөр санал хураах байранд ажиглагчаар томилогдон, бүртгүүлж үнэмлэх авсан бол ухуулга, сурталчилгаа явуулахыг хориглоно."</p>	<p>Нэр дэвшигчдийн ухуулагч, шадар туслагчаар томилогдсон этгээд санал авах байранд ажиглагчаар томилогдсон тохиолдолд санал хураах байрны гадаа ухуулга, сурталчилгаа явуулах, санал хураах байранд орж ажиглалтын үйл ажиллагаа явуулах зэрэг 2 төрлийн статустайгаар үйл ажиллагаа явуулах нь сонгууль зохион байгуулах ажлыг эмх замбараагүй болгох шалтгаан болдог.</p>

41	"Сонгуулийн ерөнхий хороо нь намын сонгууль эрхэлсэн байгууллагын улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтныг болон нэр дэвшигчийн шадар туслагчийг тус тус бүртгэж, үнэмлэх олгоно."	
42	"Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь намын сонгууль эрхэлсэн байгууллагын аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтныг болон нэр дэвшигчийн шадар туслагчийг бүртгэж, үнэмлэх олгоно."	Сонгуулийн Ерөнхий Хороо болон бүх шатны сонгуулийн хороодын ажлыг шуурхай, оновчтой зохион байгуулах.
43	"Сум, дүүргийн сонгуулийн хороо нь намын сонгууль эрхэлсэн байгууллагын сум, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтныг болон нэр дэвшигчийн ухуулагчийг тус тус бүртгэж, үнэмлэх олгоно."	
44	"Сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг төрийн аудитын байгууллагаар хянуулсан байна."	
45	"Нэр дэвшигчийн үнэмлэхийг холбогдох сонгуулийн хороо санал авах өдрөөс ... доошгүй хоногийн өмнө нэгдсэн журмаар олгоно. Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаагаа үнэмлэх авсан өдрөөс эхлүүлж, хуульд заасан хугацаанд зогсооно."	Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчээр бүртгүүлж, үнэмлэх авсан өдрөөс эхлүүлэхээр хуульчилсан нь нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа нэгэн зэрэг эхлүүлэх боломжгүй байдлыг үүсгэдэг. Иймд сонгуулийн сурталчилгааг нэгэн зэрэг эхлэх нөхцөл, боломжийг хуульчлах.
46	"Ажиглагч сонгуулийн хэсэгт ажиллах хуваариа тухайн хэсгийн хороонд гарган өгч, хуваарийн дагуу ажиглалтаа явуулна."	Санал авах байранд аливаа эмх, замбраагүй байдлыг цэгцлэх ач холбогдолтой юм.

47	"Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг радио, телевизээр төлбөртэй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг нэр дэвшигч бүрт ижил нөхцөл, боломж, тэнцүү хугацаа ногдохоор тооцож, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 15-с доошгүй хоногийн өмнө Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлана."	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг радио, телевизээр төлбөртэй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах нь төрийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийн хувьд оновчтой зохицуулалт болно.
48	"хуурч мэхлэх" гэж "үг болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох"-ыг ойлгоно.	"хуурч мэхлэх" гэсэн ойлголтыг тодорхой хуульчлах.
49	"эд мөнгөөр татах" гэдэгт мөнгө, эд хөрөнгө өгөх, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэргээр бусдын хүсэл зоригийн илэрхийлэлд нөлөөлөхийг ойлгоно.	"эд мөнгөөр татах" гэсэн ойлголтыг тодорхой хуульчлах.
50	"нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан" гэдэгт нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ хуульд заасны дагуу Сонгуулийн Ерөнхий хороонд ирүүлсэн баримт бичигтээ тусгасан төв байгууллагын бүрэлдэхүүн багтахаас гадна түүний салбар, бүтцийн байгууллагын бүрэлдэхүүн, түүнчлэн эдгээр байгууллагуудаас томилогдсон этгээдийн аль аль нь хамаарна.	"нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан" гэдэгт хэн хамаарахыг тодорхой хуульчлах
51	"ухуулагч" гэдэгт нам, эвслээс нэр дэвшигчийн болон тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг сонгогчдод тайлбарлан таниулах, нэр дэвшигчийн талаарх мэдээллийг сонгогчдод хүргэх, нэр дэвшигчээс сонгогчидтой хийх уулзалтыг зохион байгуулах үүрэг бүхий, тухайн нам, эвслээс томилогдсон этгээдийг ойлгоно.	"ухуулагч" гэдэгт хэн хамаарахыг тодорхой хуульчлах.
52	"шадар туслагч" нь зөвхөн бие даан нэр дэвшигчийн сонгуулийн ажиллагаанд туслах үүрэгтэй оролцдог бөгөөд 200 сонгогчид нэг шадар туслагч ажиллана.	"шадар туслагч" гэдэгт хэн хамаарахыг тодорхой хуульчлах.

53	<p>“нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан” болон “ухуулагч” нь нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн ажиллагаанд туслах үүрэгтэй оролцдог тул нэр дэвшигчдийн тэгш байдлыг хангах үүднээс 200 сонгогчид нэг ажилтан, эсхүл нэг ухуулагч ажиллана.</p>	<p>Намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан болон ухуулагч хэдэн сонгогч тутамд хэд байхыг хуульчлах.</p>
54	<p>“сонгууль зарласнаас хойш нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох хүртэлх хугацаанд сонгуулийн аливаа хэлбэрийн сурталчилгаа явуулахыг хориглоно.” Энэ хугацаанд сонгуулийн тухай хууль тогтоомж болон Зар сурталчилгааны тухай хуульд заасан мэдээлэл түгээх, ухуулга хийх бүхий л арга, хэлбэрийн ил, далд сурталчилгаа явуулж болохгүй.</p>	<p>Сонгуулийн сурталчилгаа явуулж болохгүй хугацааг заах.</p>
55	<p>“сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах” гэдэгт мөнгө, эд хөрөнгө өгөх, амлах, дамжуулах, зуучлах, аливаа ажил, үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэрэг төрөл бүрийн арга, хэлбэрээр сонгогчийн санал өгөх эрхийг өөрийн сонирхолд нийцүүлж, тодорхой нэр дэвшигчид санал өгүүлэх зорилгоор явуулж буй бүхий л ажиллагааг хамааруулан ойлгоно.</p>	<p>“сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах” гэдэг ойлголтыг тодорхой хуульчлах.</p>
56	<p>“хүмүүнлэгийн байгууллага” гэдэгт ядуу, нийгмийн хамгаалалтгүй, байгалийн гамшиг болон бусад онцгой учралд нэрвэгдсэн хүн амд эмнэлгийн хийгээд нийгэмшлийн тусламж үзүүлэх, байгалийн гамшгийн ба бусад онцгой учралын хор уршгийг арилгах зорилго бүхий олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын төрийн бус байгууллага хамаарна.</p>	<p>“хүмүүнлэгийн байгууллага” гэдгийг тодорхой томъёолох.</p>
57	<p>“буяны байгууллага” гэдэгт тусламж шаардлагатай хүмүүст туслах ба нийтийн сайн сайхны төлөө ажилладаг олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын төрийн бус байгууллага хамаарна.</p>	<p>"буяны байгууллага" гэдгийг тодорхой томъёолох.</p>
58	<p>“шашны байгууллага” гэдэгт Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагууд тус тус хамаарна.</p>	<p>"шашны байгууллага" гэдгийг тодорхой томъёолох.</p>

59	Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн байгууллага нь сонгогчдыг үнэн зөв, бодитой, шуурхай мэдээллээр хангана.	Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн байгууллагын гүйцэтгэх үүрэг онцгой чухал бөгөөд аливаа мэдээллийн үнэн, бодит байдлыг хангасан, тэнцвэртэй мэдээлэл бэлтгэж нийтэд хүргэх үүрэгтэй ажиллах ёстой.
60	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан нь сонгуулийн үйл ажиллагааг сурвалжлахдаа баримт нотолгоо, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан хараат бус, шударга, хууль дээдлэх зарчим, сэтгүүлчийн ёс зүйг баримтлан ажиллана.	
61	Телевиз, радио нь сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхдээ сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдлыг хангаж, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг хүргэж, редакцийн хараат бус байдлыг ханган, сэтгүүл зүйн мэргэжлийн зарчим, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.	
62	Телевиз нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ тухайн сурталчилгааны агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран дуу, дүрс, дохионы хэл, авиа, тайлбар зэргийг ашиглан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж буй гэдгээ ойлгомжтой тодорхой гаргаж, төлбөртэй, захиалгатай гэж тодотгон, тухайн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацааны туршид тухайн нэвтрүүлгийг захиалсан нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичиж нэвтрүүлэх бөгөөд энэ нь радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд хамаарна.	Телевиз нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж байгаа гэдгээ тодорхой ойлгуулж, түүний хүртээмжтэй байх нөхцлийг хангаж ажиллах ёстой.
63	Сонгуулийн сурталчилгааг улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаарх тогтмол мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, боловсролын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур нэвтрүүлэхийг хориглоно.	Сонгуулийн сурталчилгааг ямар нэвтрүүлгийн дундуур нэвтрүүлж болохгүй талаар тодорхой хязгаар тавих нь зүйтэй байна.
64	Сонгуулийн Ерөнхий Хорооноос сонгууль зохион байгуулж явуулахтай холбогдуулан сонгогчдод зориулсан сонгуулийн хууль тогтоомж болон түүнтэй холбоотой бусад мэдээллийг олон нийтийн радио, телевиз болон бусад радио телевизээр үнэ төлбөргүй нэвтрүүлнэ.	Сонгуулийн үеэр сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийг олон нийтийн радио, телевиз болон бусад радио, телевизээр үнэ төлбөргүйгээр нэвтрүүлэх нь сонгууль бүх нийтийн байх зарчмыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.
65	Телевиз, радио нь иргэдийг үнэн зөв, бодитой, тэнцвэртэй мэдээллээр хангах зорилгоор тухайн телевиз, радиогийн редакцийн зүгээс бэлтгэн нэвтрүүлсэн 2 ба түүнээс дээш нэр дэвшигч, тэдний төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, сонгуульд өрсөлдөгчдийн хооронд явуулах мэтгэлцээн зэрэг нэвтрүүлгүүдэд нэр дэвшигч, тэдний төлөөллийг оролцуулахдаа оролцогч бүрт адил тэгш боломж олгоно.	Телевиз, радиогоос зохион байгуулж байгаа хэлэлцүүлэг болон мэтгэлцээнд сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчдийн төлөөллийг оролцуулахдаа оролцогч бүрт адил тэгш боломж олгох зарчим баримталж ажиллах нь зүйтэй юм.

66	Телевиз, радио нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэж түгээх үүрэгтэй.	Телевиз, радио нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг өөрийн санаачлагаар бэлдэж ажиллахыг үүрэгжүүлэх нь зөвхөн сонгууль зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.
67	Нам, эвсэл нэр дэвшигч нь телевизээр нэвтрүүлж байгаа сонгуулийн сурталчилгааг дохионы хэлний орчуулгатайгаар нэвтрүүлнэ.	Сонголын бэрхшээлтэй буюу дүлий иргэдийн сонгох эрхийг хангах зорилгоор сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчдэд сонгуулийн мөрийн хөтөлбөр, үйл ажиллагаагаа нийтэд танилцуулахдаа дохионы хэлний орчуулга хэрэглэхийг хуульчлах.
СОНГУУЛИЙН ЗАРДАЛ		
68	Нэр дэвшүүлсэн нам нэр дэвшигчийг бүртгүүлснээс хойш 5 хоногийн дотор сонгуулийн зардлын сан байгуулж, сонгуулийн зардлын нэг дансыг арилжааны аль нэг банкинд нээлгэн энэ тухайгаа Сонгуулийн Ерөнхий Хороо, Үндэсний аудитын газарт албан ёсоор бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана.	Нам, эвсэл сонгуулийн зардлын сан байгуулах, эрх бүхий байгууллагад мэдэгдэх, нийтэд зарлах асуудлыг хуульчлах.
69	Зардлын сангийн дансанд тухайн нэр дэвшигчийн өөрийн болон нэр дэвшүүлсэн намын хөрөнгө, талархан дэмжигч нам, байгууллага, иргэдээс оруулсан мөнгөн хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зарцуулна. Нэр дэвшигч энэ данснаас өөр данс нээлгэхийг хориглоно.	Мөнгөн хандив төвлөрүүлэх, зарцуулах үйл ажиллагааг тодорхойлох.
70	Банк нь намын сонгуулийн зардлын сангийн данс нээж, энэ тухай намд болон Сонгуулийн Ерөнхий Хороонд 2 хоногийн дотор мэдэгдэнэ.	Банк сонгуулийн зардлын сангийн данс нээсэн бол энэ тухайгаа Сонгуулийн Ерөнхий Хороонд мэдэгддэг байх.
71	Сонгуулийн жил зөвхөн намын сонгуулийн үйл ажиллагаанд зориулж иргэн, хуулийн этгээдээс хандивласан мөнгөн хөрөнгийг сонгуулийн зардлын дансанд шилжүүлж төвлөрүүлнэ.	Намд зөвхөн сонгуулийн жил сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хандивласан мөнгөн хөрөнгийг сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлнэ.
72	Сонгуульд оролцогч нам, нэр дэвшигч нь сонгуулийн үйл ажиллагаанд зориулж дотогшоо чиглэсэн үйл ажиллагаа /уулзалт/-аар дамжуулан авах хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансаар авна.	Сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигчээс зохион байгуулдаг хандив цуглуулах арга хэмжээний үеэр авах хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансаар авдаг байх.
73	Сонгуулийн зардлын данс эзэмшигч, түүний эрх олгосон этгээд нь дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.	Сонгуулийн зардлын данс эзэмшигч дансны гүйлгээтэй холбогдсон баримтуудаа хадгалж, бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж холбогдох тайлан гаргахдаа хавсарган өгдөг байх.

74	Намын сонгуулийн зардлын сангийн данс байршуулсан банк, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайланг санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.	Сонгуулийн зардлын сангийн тайлан гаргаж ирүүлэх хугацааг тодорхой заах.
75	Сонгуулийн зардлын дансанд хяналт тавих зорилгоор Сонгуулийн Ерөнхий Хороо, Монголбанк хамтран санхүүгийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулж болно.	Санхүүгийн хяналтын зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, чиг үүрэг, бүрэн эрх, цалин, урамшууллын асуудлыг нарийвчлан хуульчлах.
САНАЛ АВАХ, ДҮН ГАРГАХ		
76	"Сонгуулийн Ерөнхий Хорооноос санал хураалтын дүнгийн талаар албан ёсны мэдээлэл гаргаагүй байхад аливаа этгээд санал хураалтын дүнгийн талаар мэдээ, мэдээлэл түгээхийг хориглоно."	Сонгуулийн тухай хуулиудад зааснаар нам, эвсэл, нэр дэвшигчээс томилогдсон ажиглагчид санал хураалтын дүнгийн тайлан мэдээг гаргуулан авах эрхтэй байдаг. Гэтэл сонгуулийн хороод санал хураалтын дүнг албан ёсоор нэгтгэж, Сонгуулийн Ерөнхий Хороо олон нийтэд албан ёсоор мэдээлээгүй байхад ажиглагчид болон нэр дэвшигч зэрэг субьектээс санал хураалтын дүнгийн талаар бусдад мэдээлэх, зориуд буруу ташаа мэдээллийг олон нийтэд түгээхийг хязгаарлах.
77	"хамгийн олон, гэхдээ санал өгсөн сонгогчдын ... хувийн /20-25 хувиар тогтоох/ санал авсан мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно."	Улсын Их Хурлын гишүүнээр хамгийн олон, гэхдээ санал өгсөн сонгогчдын тодорхой хувиас дээш хувийн санал авсан мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр шууд сонгогдсонд тооцдог зохицуулалтыг хэвээр хадгалж, одоогийн санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал гэсэн босгыг багасгаж 20-25 хувь болгох. Учир нь санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал гэдэг нь тойрог бүрт сонгогчдын тооноос хамаарч харилцан адилгүй байдгийг харгалзан үзэх шаардлагатай. Харин санал өгсөн сонгогчдын хувийг хасч босгогүй болгон хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохоор хуульчилбал санал хураалтын дүнгийн болоод нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасуулахтай холбогдсон сонгуулийн маргаан тухайн тойрогт нэр дэвшсэн олон нэр дэвшигчийн хооронд үүсэх магадлалтайг анхаарах шаардлагатай.

78	Сонгогчдын нэрийн жагсаалтад "түр хасав" гэсэн бүртгэлтэй гадаад улсад байгаа иргэд санал авах өдөр эх орондоо ирсэн бол өөрийн харьяа сонгуулийн хэсэгт очиж саналаа өгч болно. Гадаад улсаас эх орондоо ирж сонгуульд оролцсон сонгогчдыг сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоонд оруулан тооцно.	Санал авах өдөр гадаад улсаас эх орондоо ирсэн сонгогчдын сонгуульд оролцох эрх нь сонгогчдын нэрийн жагсаалтад "түр хасав" гэсэн бүртгэлтэй гэдэг үндэслэлээр хязгаарлагдаж байгаа болно.
79	Хэсгийн хороо зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн нэрийг үндсэн нэрийн жагсаалтын тайлбар хэсэгт тэмдэглүүлнэ.	Нэг сонгогч 2 өөр хэсэгт очиж санал өгөх эрсдлээс сэргийлнэ.
80	Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авсан хэсгийн хорооны гишүүд санал авч дууссаны дараа санал авах байранд ирж зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн нэрийн жагсаалт, саналын хайрцаг, олгоогүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийсэн саналын хуудсыг битүүмжлүүлж, саналын хуудасны тооцоог тулган шалгуулж, хэсгийн хороонд хүлээлгэн өгнө.	Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах ажиллагааг гүйцэтгэсэн хэсгийн хорооны гишүүд уг ажиллагааг дуусганы дараа хэсгийн хороонд хүлээлгэн өгөх шаардлагатай баримтуудыг тодорхой заах.
81	Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авсан хэсгийн хорооны гишүүд санал авсан тухай тайланг хэсгийн хороонд танилцуулна.	Зөөврийн хайрцгаар санал авах ажиллагааг гүйцэтгэсэн хэсгийн хорооны гишүүд ажлын тайлангаа гаргаж хэсгийн хороондоо танилцуулдаг байх.
82	Намын сонгууль эрхэлсэн байгууллага болон төрийн бус байгууллага нь гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах хүсэлтээ гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн Ерөнхий Хороонд бичгээр гаргана.	Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах тухай хүсэлтээ нам, эвсэл Сонгуулийн Ерөнхий Хороонд тодорхой хугацааны өмнө гаргадаг байх.
83	Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрлаж байгаа гадаад улс дахь салбар коммист ажиглагчаар ажиллах этгээд нь гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө салбар комисст бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.	Гадаад улсад ажиллах ажиглагчийг бүртгэх хугацааг хуульчлах.
84	Гадаадын болон Олон Улсын байгууллага нь ажиглагч бүртгүүлэх хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт санал авах өдрөөс өмнө Сонгуулийн Ерөнхий Хороонд албан ёсоор бичгээр гаргана.	Гадаадын болон Олон Улсын байгууллагаас сонгууль ажиглах хүсэлтээ яаж илэрхийлэх талаар тус Хороонд сонгууль бүрээр ханддаг.
85	Гадаадын ажиглагчийн орчуулагч нь гадаадын ажиглагчийн нэгэн адил бүртгүүлж, үнэмлэх авсан байна.	Орчуулагчийг ажиглагчийн статустайгаар бүртгэдэг байх.

86	Нам, эвсэл, хамтарсан намуудасс нэр дэвшигчийн шадар туслагч, намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтанг ажиглагчаар томилсон бол энэ журамд заасны дагуу бүртгэж, үнэмлэх олгоно.	Нэр дэвшигчийн шадар туслагч, намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан ажиглагчаар бүртгүүлэхийг зөвшөөрч, энэ тохиолдолд сонгуулийн ухуулга, сурталчилгаа хийх эрх нь дуусгавар болдог байх.
87	Ажиглагчийн эрх нь ажиглагчаар бүртгүүлж үнэмлэх авсан өдрөөс хэрэгжиж эхлэх бөгөөд тухайн ажиглагчийг бүртгэсэн сонгуулийн хорооноос санал хураалтын дүнг зарласнаар дуусгавар болно. Салбар комисст ажиллах ажиглагчийн эрх салбар комисст санал хураалт дууссаны дараа санал авахад зарцуулсан хүчинтэй, хүчингүй саналын хуудсыг битүүмжлэн гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг удирдан зохион байгуулах Комисст илгээснээр дуусгавар болно.	Ажиглагчийн эрх хэрэгжиж эхлэх болон дуусгавар болох хугацааг заах.
88	Ажиглагч нь ажиглагчийн бүртгэлээс хасагдаж, үнэмлэхээ хураалгасан бол түүнийг томилсон эрх бүхий этгээд орны хүнийг томилох эрхгүй.	Ажиглагч эрхээ хасуулбал нь орны хүнийг томилох эрхгүй байх.
89	Хэсгийн хороо санал хураалтын дүнг хэвлэн, уншин сонсгож санал хураалтын үр дүнг Сонгуулийн Ерөнхий Хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвд дамжуулсны дараа саналын хуудасны зурган болон тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан санал тоолох төхөөрөмжөөс хэвлэн гаргасан санал хураалтын дүнгийн хамт намын төлөөлөл тус бүрийн нэг ажиглагчид өгнө.	Санал хураалтын дүнтэй холбогдсон ажиглагчид өгч болох баримтыг тодорхой заах.
90	Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, бусад этгээд ажиглагчийг хуульд заасан эрхээ эдлэхэд нь аливаа хэлбэрээр саад учруулахыг хориглоно.	Ажиглагч эрхээ хэрэгжүүлэхэд аливаа этгээд саад учруулахыг хориглох.
91	Сонгуулийг ажиглахаар хүсэлт гаргасан этгээд нь сонгууль ажиглахтай холбогдон гарах зардлаа бүрэн хариуцах бөгөөд энэ нь гадаадын ажиглагчид нэгэн адил хамаарна.	Сонгууль ажиглаж байгаа этгээдээс тодорхой хэмжээний зардал /хоол, унаа гэх мэт/ гардаг бөгөөд уг зардлаа өөрөө бүрэн хариуцдаг байх.

**СОНГУУЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА,
ГОМДОЛ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХАРЪЯАЛАЛ**

92	Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчид олгосон Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэхийн хүчинтэй хугацаа нь тухайн нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөснөөр дуусгавар болно.	Ингэснээр тухайн нэр дэвшигч нэгэнт тангараг өргөж Улсын Их Хурлын гишүүн болсон бол түүнтэй холбогдох асуудлыг Улсын Их Хурлын тухай хууль болон бусад хологдох хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэдэг байх.
93	"Санал хураалтын дүнгтэй холбоотой гомдлыг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо 14 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ."	Санал хураалтын дүнтэй холбогдсон гомдол, маргааныг аймаг, нийслэлийн болон тойргийн хороо 14 хоногийн дотор заавал шийдвэрлэдэг байх талаар хуульчлах. Зохих шатны сонгуулийн хорооноос санал хураалтын дүнтэй холбогдсон гомдол, маргаан шийдвэрлэсэн бол шийдвэр гаргадаг байх. Энэ үүргээ биелүүлээгүй бол тухайн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд багтаж байгаа төрийн албан хаагчдыг төрийн албанд эргэж орох эрхгүйгээр тодорхой хугацаагаар ажлаас халах хариуцлага ногдуулдаг байх нь зүйтэй байна. Учир нь өмнөх олон удаагийн сонгуулиар зохих шатны сонгуулийн хороод маргаан шийдвэрлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүйн улмаас дээд шатны сонгуулийн хороонд эрх үүрэг нь шилжиж, маргаан шийдвэрлэгдэх хугацаа удаашрах тохиолдлууд байдаг.
94	Тангараг өргөж, бүрэн эрх нь хэрэгжиж эхэлсэн Улсын Их Хурлын гишүүн болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг эгүүлэн татахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.	Ийм томъёолол бүхий заалтыг сонгуулийн хуульд шинээр нэмж хуульчлах.

95	"санал хураалтын дүн болон сонгуулийн хороодын гомдол маргаан хянан шийдвэрлэх харъяаллын хүрээнд шийдвэрлэсэн шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл харъяалах захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ."	Сонгууль бол тодорхой тогтоосон хугацаанд явагдаад өнгөрдөг онцлогтой. Энэ онцлогт нь тохируулсан маргаан шийдвэрлэх хугацаа, механизмтай байх ёстой. Гэтэл сонгуулийн маргаан он дамжин шийдвэрлэгдэхгүй удах, үүнээс үүдэн иргэний сонгох, сонгогдох эрх зөрчигдөх, зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй болох нөхцөл байдал үүсдэг. Энэ нь сонгуультай холбоотой гомдол маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх хэргийн харъяалал болон түүнийг хянан шийдвэрлэх тусгайлсан процесс бүхий хууль байхгүйтэй холбоотой. Сонгуулийн хороод нь төрийн нэрийн өмнөөс сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж, явуулах зорилгоор байгуулагддаг, ажиллах хугацаандаа нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн шийдвэр гаргаж нийтийн эрх зүйн харилцаанд оролцдог, нийтийн захиргааны байгууллага тул захиргааны эрх зүйн субъект учир хэдийгээр сонгуулийн хуулиудад сонгуулийн маргааныг шүүхээр харъяалан шийдвэрлэхээр хуульчлаагүй ч эцсийн дүндээ сонгуулийн маргаан шүүхэд хүрч шийдэгдэх нөхцлийг бүрдүүлж байсан. Энэ тодорхой бус зохицуулалт нь сонгуулийн маргаан он дамжин шийдвэрлэгдэхгүй удах үндсэн нөхцөл болдог.
96	"Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэр хууль зөрчсөн эсэх маргааныг эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсөн этгээдийн гомдол, нэхэмжлэлийг тухайн нутаг дэвсгэрийн харъяалах захиргааны хэргийн шүүх хүлээн авч 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ."	
97	Хуулийн ... дугаар зүйлийн ... дэх хэсэгт заасан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг холбогдох сонгуулийн хороонд гаргана.	Сонгуулийн хороодын харъяалан шийдвэрлэх зөрчил, гомдлыг тодорхой хуульчлах.
98	Шат шатны сонгуулийн хорооны шийдвэрийн талаар дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргана. Үүнийг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх журамд хамааруулах бөгөөд уг журмыг зөрчиж шүүхэд гаргасан гомдлыг шүүх хүлээн авахаас татгалзаж, гомдлыг хэрхэн мэдүүлэх талаар шүүгчийн захирамжид заана.	Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх журмыг тогтоож өгөх.
99	Сонгуулийн хороодыг татан буулгах тухай шийдвэр гарсны дараа татан буугдсан сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан гомдлыг дээд шатны сонгуулийн хороо эрх залгамжлан авахыг хориглоно.	Ингэснээр сонгуулийн хороод өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар гомдол, маргааныг хуулийн хугацаанд багтаан бүрэн шийдвэрлэдэг байх хариуцлагыг буй болгоно.

100	Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулиас бусад хуулийг, Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд олгогдсон сонгох, сонгогдох эрхээс бусад эрхийг зөрчсөн талаарх гомдлыг Сонгуулийн Ерөнхий хорооны оршин байгаа дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.	Сонгуулийн Ерөнхий Хорооны хууль зөрчсөн шийдвэрийг харьяалан шийдвэрлэх шүүхийн харьяалалыг тодорхой болгох.
101	Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаарх гомдол, хүсэлтийг Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу Үндсэн хуулийн цэцэд гаргана.	Сонгуулийн Ерөнхий Хорооны шийдвэр Үндсэн хууль зөрчсөн тухай гомдол, мэдээлэл гаргах харьяаллыг тодорхой болгох.
102	“итгэмжилсэн хүн” гэж сонгогчийн өөрийн хүсэл зоригийн дагуу тухайлан сонгож, санал авах байранд дагуулж ирсэн, санал өгөхөд нь унших, бичих хэлбэрээр туслалцаа үзүүлэх чадвартай, насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг хэлнэ. Сонгогчийн итгэмжилсэн хүний эрх зүйн байдлыг түүний иргэний үнэмлэхээр тодорхойлно.	"итгэмжилсэн хүн" гэдэгт хэнийг хамааруулж ойлгохыг тодорхой хуульчлах.
103	“сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн” гэдэгт сонгогчийн саналаа чөлөөтэй өгөх эрхэд хөндлөнгөөс хууль бусаар аливаа хэлбэрээр нөлөөлсний үр дүнд түүний саналыг хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл, түүнчлэн санал хураалтын эцсийн дүнг бодит байдалд нийцсэн дүн гэж тус тус үзэх боломжгүй болохыг ойлгоно.	"сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн" гэдгийг тодорхойлох.
104	“шүүхийн шийдвэр” нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хуулийн хүчин төгөлдөр болсон буюу түүний талаар дахин гомдол гаргах, маргааны зүйлийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, тухайн үйл баримт, эрх зүйн харилцааны талаар өөр ажиллагаанд маргах, шийдвэрийг дээд шатны шүүхээс өөрчлөх, хүчингүй болгох тус тус боломжгүй болсон байхаас гадна уг шийдвэрийг заавал биелүүлэх үүрэг иргэн, хуулийн этгээдэд үүссэн байна.	"шүүхийн шийдвэр" гэсэн ойлголтыг тодорхой хуульчлах.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО